

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ"  
ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар  
/дүгээр/ сарын 23-ны өдрийн 26/2022  
тоот тушаалын хавсралт 01



SOLOMON INVESTMENTS

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ ЖУРАМ

Баримт бичгийн төрөл/ Type:	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
Хамрах хүрээ/ Area:	"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-ИЙН холбогдох ажилтнуудад
Нууцын зэрэглэл/ Confidentiality:	Дотоодод нээлттэй
Баримт бичгийн дугаар/Number:	...м / 26 / 36
Боловсруулсан/ Prepared by:	.....
Баталсан/ Approved by:	"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Хуудасны тоо/ Page number:	...4... хуудас
Хянан нийцүүлэх давтамж:	...нийгд 1 удаа
Батлагдсан огноо/ Effective date:	2026 оны 03 дүгээр сарын 23

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү "Соломон Инвестментс ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам (цаашид "Журам" гэх)-ын зорилго нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах, хурлын зар, мэдэгдлийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын бэлтгэл хангах болон түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү Журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн засаглалын кодекс болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулагдсан болно.

### ХОЁР. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ

- 2.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "Хурал" гэх) нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.
- 2.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан хугацаанд зарлан хуралдуулна.
- 2.3. ТУЗ нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан үндэслэлээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах эрхтэй бөгөөд холбогдох санал, шаардлагыг хүлээн авснаас хойш хуульд заасан хугацаанд хурлыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.
- 2.4. Энэхүү Журмын 2.3-т заасан хугацаанд ТУЗ шийдвэр гаргаагүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасан эрх бүхий этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.
- 2.5. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах асуудлыг тусгана. Үүнд:
  - 2.5.1. Хурал хуралдуулах газар, он, сар, өдөр, цаг;
  - 2.5.2. Хурлаар хэлэлцэх асуудал;
  - 2.5.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
  - 2.5.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам;
  - 2.5.5. Хурал хуралдуулахаас өмнө хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалт;
  - 2.5.6. Хурал хуралдуулах хэлбэр;
  - 2.5.7. Хурлын дарга;
  - 2.5.8. Тооллогын комиссын дарга, гишүүд;
  - 2.5.9. Хурал даргалах этгээдийн албан тушаал.
- 2.6. Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтыг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцүүлэн боловсруулна.
- 2.7. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг ТУЗ тогтооно.
- 2.8. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн этгээд хуралд оролцох эрхтэй байна.

### ГУРАВ. ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ

- 3.1. ТУЗ эсхүл Компанийн эрх бүхий албан тушаалтан нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 05 дугаар сарын 01-ны дотор, ээлжит бус хурлыг хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.
- 3.2. Хурлын зарыг цахим шуудан, шуудан, мессеж болон бусад холбооны хэрэгслийн аль боломжтой байдлаар хүргүүлж болно.
- 3.3. Шаардлагатай тохиолдолд хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд дахин сануулах зорилгоор хурал болох өдрөөс өмнө нэмэлт мэдэгдэл хүргүүлж болно.
- 3.4. Хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:
  - 3.4.1. Компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;
  - 3.4.2. Хурал зохион байгуулах хэлбэр (танхимын, цахим, холимог);
  - 3.4.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр;
  - 3.4.4. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
  - 3.4.5. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичигтэй танилцах журам, хугацаа;
  - 3.4.6. Хурлыг зохион байгуулахтай холбоотой холбоо барих мэдээлэл;
  - 3.4.7. Хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан бусад мэдээлэл.

#### **ДӨРӨВ. ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 4.1. Компани нь дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
  - 4.1.1. ТУЗ-ийн тогтоол гарсан;
  - 4.1.2. Хувьцаа эзэмшигчид санал, хүсэлт гаргасан;
  - 4.1.3. Гамшиг, онцгой нөхцөл байдал болон бусад шалтгаанаар танхимаар хурал зохион байгуулах боломжгүй болсон.
- 4.2. Журмын 4.1-д заасан хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
  - 4.2.1. Танхимаар буюу хувьцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах замаар;
  - 4.2.2. Мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр;
  - 4.2.3. Танхимаар болон зайнаас хосолсон байдлаар;
  - 4.2.4. Ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар.
- 4.3. Цахим хурал зохион байгуулах мэдээллийн технологийн систем нь дараах боломжийг хангасан байна. Үүнд:
  - 4.3.1. Хурлын зар, хэлэлцэх асуудал болон холбогдох материалтай танилцах;
  - 4.3.2. Хуралд бүртгүүлэх;
  - 4.3.3. Санал, асуулт урьдчилан хүргүүлэх;
  - 4.3.4. Хурлын үйл ажиллагааг шууд үзэх;
  - 4.3.5. Санал өгөх, асуулт тавих, хэлэлцүүлэгт оролцох;
  - 4.3.6. Санал хураалтын нууцлал, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах;
  - 4.3.7. Санал хураалтын дүн болон хурлын шийдвэртэй танилцах;
  - 4.3.8. Хурлын холбогдох баримт материалтай танилцах.
  - 4.3.9. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, мэдээлэлт хамгаалалтын аюулгүй байдлыг хангасан байх.
- 4.4. Цахим хурлыг Zoom, Microsoft Teams, Google Meet болон түүнтэй адилтгах цахим харилцааны программ хангамж ашиглан зохион байгуулж болох бөгөөд ашиглах программ хангамж нь мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалтын шаардлагыг хангасан байна.

- 4.5. Техникийн саатал, доголдлоос шалтгаалан хурлыг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд ТУЗ хурлыг түр завсарлуулах, хойшлуулах эсхүл дахин товлох тухай шийдвэр гаргаж болно.
- 4.6. Энэхүү бүлгийн зохицуулалт нь давагдашгүй хүчин зүйл болон бусад онцгой нөхцөл байдалд мөн адил хамаарна.

#### **ТАВ. БУСАД**

- 5.1. Хурал зарлагч нь хурлыг Компанийн төв байрнаас өөр газарт зохион байгуулахаар товлосон бол хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, хүртээмжтэй, тохиромжтой байршлыг сонгоно.
- 5.2. Хуралд оролцоогүй эсхүл хурлын шийдвэрийг эс зөвшөөрсөн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон энэхүү журмыг зөрчсөн гэж үзвэл хууль тогтоомжид заасан журмын дагуу гомдол, шаардлага гаргах эрхтэй.
- 5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, шийдвэр гаргах ажиллагаанд хууль тогтоомж, Компанийн дүрэм, энэхүү журмыг зөрчсөн нь тогтоогдсон бол холбогдох асуудлыг эрх бүхий байгууллага хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

#### **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

- 6.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол Компани холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулна.
- 6.2. Энэхүү журмыг зөрчсөний улмаас Компани болон гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол буруутай этгээд хууль тогтоомж болон Компанийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 6.3. Энэхүү журмыг зөрчсөний улмаас Компанийн нэр хүнд, бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулсан бол буруутай этгээд хууль тогтоомж болон Компанийн дотоод журамд заасны дагуу холбогдох хариуцлага хүлээнэ.
- 6.4. Энэхүү журмаар зохицуулаагүй асуудлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.